

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244812

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАН БУС
БЭЛГЭДЛИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Д.Нямдорж

Хураангуй: Богд Хаант Монгол Улсын төрийн бэлгэдлийг бүтээхдээ Хүннү гүрний үеэс эх үүсгэлтэй монгол төрийн бэлгэдлийн уламжлал хийгээд эртний Энэтхэгээс үүдэл гаралтай хэмээдэг төрийн хос ёсны бэлгэдлийн уламжлалыг эвсүүлэн найрсуулж хэрэглэжээ.

Эл төрийн бэлгэдлийн онцлог бол шашин төрийг хослон баригч хэмжээгүй эрхт хааны эрх сүрийг өргөж, түүнээ бэлгэ тэмдэг бүрээр харуулахын зэрэгцээ үүндээ монгол төрийн уламжлал хийгээд эртний Энэтхэгийн төр, шашны бэлгэдлийг эвсүүлэн найрсуулж олон улсын жишгийг харгалзан тусгаж, ингэснээрээ тусгаар тогтносон, бүрэн эрхт улсыг байдлыг илтгэн харуулж байсанд оршино.

Хуульд тусгагдсан байдлаар нь Богд хаант Монгол Улсын төрийн бэлгэдлийг дотор нь албан ёсны болон албан бус гэж хоёр ангилж болохоор байна. Албан ёсны бэлгэдэлд “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-т хуульчилж өгсөн төрийн сүлд, төрийн далбаа, төрийн тамга гэсэн гурван бэлгэ тэмдэг орж буй бол албан бус бэлгэдэлд хэдий хуульчлан батлаагүй ч хэрэглэж байсан төрийн дуулал, хаан төрийн долоон эрдэнэ зэрэг бэлгэ тэмдэг орно.

Тус өгүүлэлд Богд хаант Монгол Улсын төрийн албан бус бэлгэдлийн уламжлал, шинэчлэлийн асуудлыг авч үзлээ. Ингэхдээ төрийн дууллын талаар хийсэн судалгаа болон хаан төрийн долоон эрдэнийн тайлбаруудыг харьцуулан шинжилж, утга бэлгэдлийг тодруулсан болно.

Түлхүүр үг: Зуун лангийн жороо луус, төрийн дуулал, хаан төрийн долоон эрдэнэ

Монголчууд 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, наймдугаар Богд Жавзандамба хутагтыг Их Хүрээнээ Монгол Улсын эзэн, шашин төрийг хослон баригч, наран гэрэлт, түмэн наст Богд хаанд өргөмжлөх их ёслолын үеэр тамга тэргүүтэй төрийн бэлгэ тэмдгийг үйлдэн бусад бэлэг сэлтийн хамт түүнд өргөжээ. Чухам юу өргөснийг архивын эх сурвалжаас тодруулж үзвэл Богд хаанд хундага өргөхөд чин ван Ханддорж, гүн Намсрай, тамга өргөхөд да гүн Чагдаржав, өргөмжлөлд сайн ноён Намнансүрэн, жанжин бэйс Гомбосүрэн, мандалд Түшээт хан Дашням, Сэцэнхан Навааннэрин, бурханд хамба номун хан Пунцаг, дэд хамба Содномдаржаа, ном дор Манзушир хутагт Цэрэндорж, Жалханз хутагт Дамдинбазар, суваргад ноён номун хан Жигмэддорж, Эрдэнэ хамба Лувсанцэрэндагвадогми, долоон эрдэнийг Шанзодба Бадамдорж, мэргэн хамба Дэмбэрэлдаш, түмэн оны хангагчийг да жүн ван Гомбосүрэн, мэргэн ван Ананд Очир, ерөөл айлтгахад Да лам Цэрэнчимэд нар гүйцэтгэсэн байна¹.

¹ Үндэсний Төв Архив, ф. АЗ, д. 1, х. н. 2, 16 дахь тал.

Богд хааны зарлигаар 1915 оноос эхлэн тухайн үеийн Монголын сор, төрийн түшмэд, шашны зүтгэлтнүүд хамтран өөрийн төрийн хууль цаазын уламжлал болон дэлхий нийтийн хууль цаазын жишигт онцлогт тулгуурлан боловсруулж 1918 онд дуусган батлуулсан, 65 дэвтэр бүхий “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” (2018)-т төрийн зарим бэлгэ тэмдгийг хуульчлан зааж өгчээ.

Монгол Улсын төрийн бэлгэдлийг хуульд тусгагдсан байдлаар нь албан ёсны болон албан бус гэж хоёр ангилж болно. Албан ёсны бэлгэдэлд “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-т хуульчилж өгсөн төрийн сүлд, төрийн далбаа, төрийн тамга гэсэн гурван бэлгэ тэмдэг ордгийн уламжлал, шинэчлэлийн асуудлыг товчхон авч үзвэл дараах байдалтай юм.

Төрийн сүлдний тухайд Монгол Улсын шашин төрийг хослон баригч хаанаар өргөмжлөгдсөн наймдугаар Богд Жавзандамба хутагтын анхдугаар дүр, Өндөр гэгээн Г.Занабазарын зохиосон соёмбо бичгийн тэргүүн тэмдэг, титэм үсгийг сонгон хэрэглэсэн. Хожим мутрын тэмдгээ болгосон гэгддэг энэ тэмдгийг тэрбээр бүтээхдээ Монголын эртний сүлд болох нар, сар, галын дүрсийг оройд нь залж, монгол тамгадын дүрсийг оролцуулан, эртний Энэтхэгийн бэлгэдлийн ёгт ном “Нанживандан” үсгэн хээнээс эх авч, тусгаар тогтносон Монгол Улсыг бэлгэдсэн нь ийн биелсэн байна. Монгол Улсын албан ёсны сүлд соёмбыг энэ цагаас анхдугаар Богд Жавзандамба хутагтын зохиосон тэмдэг, Богд хааны урд дүрийн сүлд төдий бус монгол төрийн бэлгэ тэмдэг гэх үзэл, итгэл үнэмшил улам батжин гүнзгийрчээ.

Төрийн далбааны тухайд хэдийгээр түүнийг байгуулах тухай баримтад олон улсын жишгийг харгалзан үзсэн нь тодорхой байгаа ч монгол төрийн түүхнээ Хүннү гүрний үеэс эхлээд таван өнгөт далбаа байгуулж байсан болон дундад зууны үед 44 Хөх Монголыг төлөөлсөн 44 хэлт хөх дарцаг хэрэглэж байсан түүхтэй тул уламжлал шинэчлэлийг хослуулсан гэж үзүүштэй байна. Монгол Улсын төрийн далбааны гурван хэл дээрх тарнийн үсэг, шаргал дэвсгэр дээрх мөргөлийн номын бичээс зэрэг нь шашныг, харин төв дундах таван махбодын өнгөт, хүрээтэй соёмбо нь төрийг тус тус бэлгэдсэн байдаг. Монгол Улсын төрийн далбааг ийн шинээр байгуулснаас гадна цэргийн далбааг үйлдэж, нэгж бүрд тохируулсан далбаа шийтгэн олгож, нэршлийг нь тогтоон өгч, тугаас хиур хүртэлх далбааны зүйл дээр байрлуулах зүйлд, бичиг зэргийг хуульчлан зааж өгсөн нь онцлууштай хэрэг юм.

Төрийн тамгыг үйлдэхдээ эртнээс уламжлалтай дөрвөлжин хэлбэрийг барьж, Богд хааны төрийн тэргүүн тамгыг хашаар бүтээсэн нь, Хүннү гүрний хаад болон Их Монгол Улсын далай хааны хасбуу тамганы уламжлалыг дагасан хэрэг юм. Тамган дээрээ монголын гурван үсгээр “Төр шашныг хослон баригч наран гэрэлт Богд хааны тамга” хэмээх үгсийг сийлсний эхэнд төрийн сүлд, тэгээд соёмбо бичгээр найман мөр дэглэсэн нь анхдугаар Богдын зохиосон бичгийг хэрэглэснээс гадна түүний наймдугаар дүр хаан ширээнд заларч Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээсэн гэдгийг, тамганы төвд монгол бичгээр сийлсэн нь хуучин Манж Чингийн тамганд төвийн бичээсийг манжаар сийлж эзний эрхийг

харуулдаг байсан ёсыг дагаж, монгол төрийн тамга гэдгийг, зүүнтээд дөрвөлжин бичгээр сийлсэн нь Богд хаан болбоос Их Юан Улсын хаан Хубилайн адил төрийн хос ёсоор засаг явуулагч хаан гэдгийг тус тус бэлгэдсэн байдаг. Түүнээс гадна тамган дээрх хааны цол нь эртний Энэтхэгийн домогт, олноо өргөгдсөн Махасамади цол гэдгийг санууштай юм.

Мөн Богд хаанд хаш тамганаас гадна хэлбэр, дүрслэлийн хувьд адилхан хэмжээ ялимгүй том төрийн мөнгөн тамга бариулж, дарах бичгийн зэргэмжээс хамаарч, тэргүүн зэргийн хэргээс бусдад дарж байсан ба хааны төрийн хоёр тамганы бариулыг төр шашны хос ёсыг явуулагч хааны төрийн долоон эрдэнэ нэг болох чандмань дүрстэй урласан байдаг. Түүнчлэн хааны төрийн тамгадаас бусад яамны тамгадаас эхлэн бүх төрийн тамгыг нэгэн хэв, загварт оруулж, хэмжээг дөрвөлжин, төвд нь төрийн сүлд, хоёр хажуугаар нь монгол үсэг сийлж, бариулын чандманийн үзүүрийн тоо, тамганы хэмжээ, жин, эд зэргээр албаны зэрэглэлийг нь тогтоож өгсөн.

Харин Богд хаант Монгол Улсын төрийн албан бус бэлгэдэлд хэдий “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-т хуульчлан батлаагүй ч тухайн үед хэрэглэж байсан төрийн дуулал, хаан төрийн долоон эрдэнэ зэрэг бэлгэ тэмдэг ордог. Энэ хоёр бэлгэ тэмдгийн уламжлал, шинэчлэлийг тус бүрчлэн дэлгэрэнгүй авч үзье.

Богд хаант Монгол Улсын төрийн дуулал: Богд хаант Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгүүдийг бүтээхдээ дэлхий нийтийн жишгийг харгалзан үзэж байсныг төрийн далбааг бүтээхдээ “Олон улсын дор цөм өөр өөрийн далбаа буй, бидний монгол болбоос өөрөө эзэрхэх эрх хэмжээ бүхий нь мөн тусгайлан далбаа байгуулж тусгаар эрх бүхийг илэрхийлбэл зохимой” (Нямбуу, 1979: 18) хэмээснээс тодорхой харж болно. Тэгвэл монголчууд, тэр тусмаа Богд хаан, түүний шадрууд 1911 оноос өмнө бусад улсын төрийн дуулалтай танилцаж байсныг түүх өгүүлж байна.

Тухайлбал, 1910 оны зургаадугаар сарын 14-ний өдөр Богд гэгээн В.Л.Попов тэргүүтэй Оросын худалдааны шинжилгээний ангийнхныг хүлээн авч уулзах үеэр бүрэлдэхүүнд нь явсан хөгжмийн зохиолч Б.Б.Красин тухайн үеийн Оросын төрийн дууллыг тоглож өгсөн нь тэдний өдрийн тэмдэглэлд үлджээ .

Энэ үйл явдлыг 1912 онд хэвлэгдсэн “Московская торговая экспедиция в Монголию” номын 44-45 дугаар талаас Д.Цэдэвийн орчуулгаар авч үзвэл “... Богд гэгээн бүхий л барааг үзээд таалагдсан юмаа сонгоод үнэ цэнийг нь тохирч сүүлд нь Орос ардын дуутай пянзнуудыг эгшигт хайрцагтаа тавьж, хөгжмөөр биднийг дайлав... Бидний дунд шинжилгээний ангийн сайн дурын гишүүн, Оросын хөгжмийн залуу зохиолч Б.Б.Карасин явсан юм. Тэр Богд гэгээнд төгөлдөр хуур байгаа эсэхийг асуух, монгол дуу аялгууг цуглуулахаар яваа болохлоороо монгол дуунуудаас ямрыг нь ч хамаагүй тоглож өгөх санал гаргасан юм. Төгөлдөр хуур үзэгдсэнгүй, харин хөөрөгт даруул хуур (фисгармони) байсныг төдөлгүй хашаан дотор гаргаж ирсэн юм. Хөөрөгт даруул хуур нь гэмтэлтэй ч гэсэн Б.Б.Карасин хэдэн аккорд аваад “Юу тоглох вэ?” хэмээн асуусан юм. Хэн нэг нь “Оросын

сүлд дуу” гэж санал болгов. Орос хүний сэтгэл зүрхэнд ойр дөт, ардын сүлд дуул болох “Боже, царя храни” (Бурхан минь, хааныг өршөө Д.Н) гэдэг сүр жавхлант аялгуу монголын талд цуурайтлаа. Бид бүгдээр малгайгаа авч хөгжимдөгч хүнээ ёслол төгс хүрээлэн зогслоо. Богд гэгээн эхнэрийнхээ (хатныхаа Д.Ц) хамт ноёд түшмэд, бараа бологчидтойгоо тугдам өргөөнөөсөө гарч ирээд юу тоглож байгааг тайлбарлахад титмээ авч монголын оройн дээд Богд гэгээн үндэсний өргөөндөө Цагаан хааны сүлд дууг хүндэтгэлтэй чимээгүй номхон зогсож сонслоо. Сүлд дууг эгшиглэж дуусуут шинжсигээний ангийнхан урай хашигирч бас ч сүлд дууг хоёронтоо давтан тоглосны нэг нь Богд гэгээний хүсэлт байсан” (2005: 161-162) гэсэн байна.

Дээрх баримтыг Д.Цэдэв “тусгаар улс өөрийн сүлд дуутай, түүнийгээ хэрхэн хүндэтгэн ёсолдгийг Богд гэгээн болон тус шинжсигээний ангийнхныг Жибзундамбад бараалхуулахыг зохион байгуулж хамт байлцсан Чин ван Ханддорж нар үзсэн нь Олноо өргөгдсөн хаан Монгол Улсыг байгуулах үес, тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг цогцлоон бүрдүүлэхэд “Сүлд дуу” чухал гэдгийг санахад нэмэр болсон байж таарна” (2005: 162) гэж үзсэнтэй бид бүрэн санал нийлж буй бөгөөд үнэхээр ч 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн тунхагласныхаа дараа Монгол Улсын Засгийн газар тусгайлан захиалж төрийн дуулалтай болжээ.

Энэ тухай “Огонёк” сэтгүүлийн 1914 оны дөрөвдүгээр сарын зургаанаас 19-ний дугаарт нийтлэгдсэн “Сэргэн мандаж байгаа монгол” өгүүлэлд “... Хутагтаас (Богд хаан Д.Н) Монголын үндэсний сүлд дууг цэргийн үлээвэр хөгжмөөр тоглож байх тухай зарлиг гаргаж байжээ. Монголын Засгийн газрын тусгай захиалгаар Оросын хөгжмийн зохиолч Кадлец Сан.Петербургийн Их Сургуулийн Дорно дахины факультетээс өгсөн монгол аялгуугаар сүлд дуу бичжээ. Сүлд дууны зохиогч нь Марийнскийн (Марийний) театрын нэгдүгээр хийлч байсан төдийгүй бас хөгжмийн нэртэй зохиолч юм. тухайн үедээ Марийнскийн театрын тайзнаа тавигдаж байсан бүжгийн жүжгийг бичсэн юм. Сүлд дууг бичсэний төлөө Хутагтын дэд зэргийн дөрөвдүгээр “Эрдэнийн очир” одонг авчээ” гэж тодорхой мэдээлсэн байна.

А.Д.Рудневын “Материалы по говорам Восточной Монголии” номын 34 дүгээр талд байгаа “Хасар богдын эрхин үрс” гэсэн эхлэлтэй дууг А.В.Кадлецын бичиж нотолсон аялгуутай харьцуулж үзээд Д.Цэдэв аялгууны бүтэц ижил, дэвсгэр хөг нэг, хурдац адил нэгдмэл, хөгжмийн ерөнхий сэтгэлгээ донж намба төстэй, ганц хоёр эгшгийн зөрүүтэй ч өндөрлөгүүд нь ойролцоо буйг гаргаж, Жирмийн чуулганд дэлгэрч байсан уг дууны аяыг монголчуудын дуулж байсан “Зуун лангийн жороо луус” дууны аялгуутай хослуулан үндсэн ая болгож үлээвэр найрал хөгжимд тоглоход зориулан найруулсан болохыг тогтоожээ. Мөн А.В.Кадлецад үлгэр болох монгол аялгууг өгсөн Сан-Петербургийн Их Сургуулийн Дорно дахины факультетад тухайн цагт эрдмийн зэрэг хамгаалахаар суралцаж байсан А.Д.Руднев аялгууны сонголтод оролцсон байж болохыг дурдсан байна. Үгүй юм гэхэд төрийн дууллын аялгууг хаанаас эхтэйг тэр лавтай мэдэж байжээ.

“Зуун лангийн жороо луус” дууг Г.Жамсранжав Сэцэний Гомбожав (1969: 14), П.Хорлоо Цэрэнсандэв дууч (1981: 71), Д.Дэмбэрэл М.Дашрэнцэн дууч (1988: 41), А.Норовсамбуу Г.Цэрэнчимэд да лам (1999: 43-45) зохиосон гэсэн бол Д.Лувсаншарав Дондогдулам хатан зохиосон гэх яриа сонссон (Цэдэв: 2005, 178), До.Цэнджав Дэндэвдулам хатан үгийг нь зохиосон байж магадгүй (2016: 246), Ж.Болдбаатар Богд хаан, Эх дагина, ойр шадар төрийн сайд, ордны түшмэл, дуучин хөгжимчин зэрэг янз бүрийн түвшний хүмүүсийн хамтын бүтээл байсан байна (2009) гэж таамаглал дэвшүүлжээ. Гэхдээ эдгээрийн аль нь ч тодорхой баримтгүй, таамаглал төдий байгаа юм.

Д.Цэдэв Б.Я.Владимирцовын хэвлүүлсэн зургаан дуу (1970: 1, 2, 5-6, 31, 54-55), Б.Ринчений хэвлүүлсэн гурван дуу (1972: 178-179), тэдгээрийн хувилбарыг анхааран үзэж, С.Буяннэмэхийн гар бичмэл, Н.Поппегийн тэмдэглэл (1955: 28-31), Сайн ноён хан аймгийн сайн ноён ханы хошуу, өнөөгийн Өвөрхангай аймгийн Богд сумын харьяат “Нарийн хоолой” хэмээн алдаршсан дуучин Балдангийн Нацагаас нас сүүдэр ная зэрэгцэж байхад нь 1970 оны тавдугаар сарын 21-ний өдөр өөрийн биеэр тэмдэглэж авсан хувилбараа харгалзан “Зуун лангийн жороо луус” дууны анхны дуулж байсан болов уу гэх нэгэн эхийг сэргээсэн нь дараах буюу (2005: 184-185)

1. *Зуун лангийн жороо луусыг
Жуузан дундаа хөлөглөнө өө хө
Зураг болсон Богд ламыгаа
Зонховын ширээнд зална аа хө*
2. *Түмэн настай Богд эзэн минь
Шар тугдамдаа залрав аа хө
Төрийн тулгуур олон сайдууд
Төвшин ордондоо цуглав аа хө*
3. *Наран гэрэлт богд эзэн минь
Алтан жуузандаа залрав аа хө
Наян түмэн шавь нар нь
Амь насаа даатгав аа хө*
4. *Алтан амтай бүрээ бишгүүрээ
Асрын үүдэнд хангинуулна аа хө
Аврал ихтэй Богд ламыгаа
Авралын ширээнд зална аа хө*
5. *Мөнгөн амтай бүрээ бишгүүрээ
Мөргөлийн үүдэнд хангинуулна аа хө
Мөрөөдөл болсон Богд ламыгаа
Мөрний эхэнд зална аа хө*
6. *Алтан амтай бишгүүрээ
Асрын дундаа татна аа хө
Арын олон ноёдууд
Даншиг мандлаа өргөнө өө хө*

7. *Мөнгөн амтай бүрээ бишигүүрээ
Мөргөлийн дундаа татна аа хө
Мөнхийн олон шавь нар нь
Мөргөөд хүслээ хангана аа хө*
8. *Далай ламын зарлигтай
Дайсан хортон дарагдах болтугай
Дара эх бурхнаа адистай
Даяар хамт жаргах болтугай.*

Дээрх Монгол Улсын төрийн дууллын нэгдүгээр бадгаас “Богдыг бурхны шашны тэргүүн боллоо гэсэн санаа урган гарч байгаа юм” (Цэдэв, 2005: 187) гэж үзсэн нь туйлын үнэн бөгөөд үүнийгээ сүүлийн хоёр мөрөөр бат илэрхийлжээ. Харин эхний хоёр мөр түүнийг амьд бурхан хэмээн итгэж шүтэж, дээдлэн хүндэлж байсныг харуулна. Учир нь луус “хааны унаа, бие бялдар торниун, явдал суудал хөнгөнтэйн бодит үнэнийг тусгасан авч Балданлхам бурхан луус хөлөглөдөг гэдгийг лавтайяа бодолцжээ” (Цэдэв, 2005: 186).

“Өөр нэгэн учир шалтгаан бол Богд Жавзандамба хутагтын урьд төрлийн цадигтай холбоотой болохыг хутагтын гуравдугаар дүр Иидамбийнъямын найман сүүдрийн үедээ Их Хүрээнд сууж байгаад хэрэг буруудсан нэгэн амбаныг аврал эрэн мөргөхөд хэлсэн үг болно. Тэр амбан Богдод мөргөж нүглээ наманчлан “Та намайг өршөөлөө. Танд биширч байна. Би үүнийхээ учрыг өөрөө ч мэдэхгүй юм” гэхэд “Аргагүй ээ, чи санахгүй байгаа байх. Олон төрлийн өмнө юм сан. Би луус унаад явж байлаа. Хөөрхий тэр луус надад их тус болсон... Түүний учир таны суганд хоёр хар мөнгө бий байх” гэв. Тэрхүү амбан хоёр сугандаа нээрээ хоёр мэнгэтэй юм санж” гэхчлэн өгүүлдэг (Хүрэлбаатар ба Жамсранжав, 2010: 197). Үүгээр үзвэл луус бол Богд Жавзандамба хутагтуудын урьд төрлийн хүлэг унаа байсантай холбогдож байна” (Дулам, 2010: 30).

Ийм давхар бэлгэдлийн үүднээс луусыг сонгосон бол “Зуун лан”-гаар түүний үнэ цэнийг тодотгон дараагийн мөртэй толгой холбожээ. Мөн “...ардын дуунд болон Д.Равжаагийн зохиолд “Богдыг залах”, “Дөрвөлжин шар жууз”, “Алтан сайхан бишигүүр”, “Мөнгөн сайхан бишигүүр” гэсэн хэллэг олонтоо байсан нь урьд урьдын Богд Жибзундамбыг залах үеэс гарсан дууллаас уг сурвалжтай гэж үзмээр байгаа юм” (Цэдэв, 2005: 183) гэж үзсэнтэй учир холбогдож байна.

Тэгвэл хоёр, гуравдугаар бадгаар тэргүүн бадагт илэрхийлсэн шарын шашны тэргүүн Богд Жавзандамба хутагтыг хаан сэнтийд салсныг илэрхийлжээ. Хоёрдугаар бадгаас “Богд Жибзундамбыг төрийн тэргүүн, улсын эзэн боллоо гэсэн утга илэрч байгаа юм. Эзэн хаантай байна гэдэг нь тусгаар тогтносон улс боллоо гэсний тэмдэг билээ” (Цэдэв, 2005: 187) гэсэнтэй санал нийлэхийн зэрэгцээ үүнийг бататгах мөрүүд нь бадаг бүрийн эхэнд байна. Тодорхой өгүүлбэл хоёрдугаар бадгийн эхний мөрийн “Түмэн настай Богд эзэн минь”, “Наран гэрэлт Богд эзэн минь” гэсэн үгс бол Богд Жавзандамба хутагтыг хаан өргөмжлөөд өргөсөн цол юм.

Үүнийг их ёслолын үеэр зууч түшмэлээс айлтгасан ерөөлийн “Богд гэгээнтнээ Монгол Улсын шашин төрийг хослон баригч наран гэрэлт түмэн наст Богд хаанд өргөмжлөн” гэх хэсгээс болон хааны хаш, мөнгөн тамгад дээрх “Шашин төрийг хослон баригч, наран гэрэлт Богд хааны тамга” гэсэн бичээс зэргээс харж болно. Энэ санааг бататган хоёрдугаар бадгийн сүүлийн хоёр мөрөөр бүр ч тодорхой харуулжээ.

Өгүүлэмжийн хувьд эхний бадагт наймдугаар Богд Жавзандамба хутагтыг залсныг, хоёр, гуравдугаар бадагт Монгол Улсын шашин төрийг хослон баригч хаанд өргөмжлөгдсөнийг нь цуваа цагийн үүднээс өгүүлж, сүүлд дуулж хөгжимдөж байсан богино хувилбарт зөвхөн эхний бадгийн өгүүлэмжийг дэлгэрүүлсэн байна. Хоёр, гурав, зургаа, долоо, наймдугаар бадгийг сүүлд нэмж зохиосон ч байж болох юм. Учир нь богино хувилбарын бадгуудын сүүлийн хоёр мөр Богд ламын тухай бол орхигдсон гэж буй бадгуудын эхний дөрвөн бадгийн сүүлийн хоёр мөрүүд өмнөхтэй адил биш, төрийн тулгуур олон сайдууд, наян түмэн шавь нар, арын олон ноёд, мөнхийн олон шавь нар зэргээр дүрүүд нь өөр өөр байна.

Богд хаант Монгол Улсын төрийн долоон эрдэнэ: Наймдугаар Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын хаан сэнтийд залах их ёслолын үеэр түүнд өргөсөн олон зүйлийн дунд “долоон эрдэнэ”, “хааны эрдэнэ” (Магсаржав, 1994: 12) гэж түүх сурвалжид хоёр янзаар тэмдэглэгдэн үлдсэн зүйл бол угтаа хаан төрийн долоон эрдэнэ (**Зураг 1**) гээч нэгэн зүйлийн бэлгэ тэмдэг юм. Үүнд хүрд, чандмань, хатан, түшмэл, заан, морь, жанжин орно. Эдгээр нь эрт цагийн Энэтхэгийн Чакравартин хааны эзэмшиж байсан долоон эрдэнэ гэгддэг.

Чакравартин гэх үгийг ихэвчлэн “ертөнц дэхиний эзэн, бүгдийн эзэн, бүгдийн хаан” гэж орчуулдаг ч үгчлэн буулгавал “хүрд эргүүлэгч, хүрд орчуулагч юм уу, хаа сайгүй сааталгүй эргэгч хүрд” гэсэн утгатай юм. Мөн чакра буюу хүрд гэсэн үг нь нарны галт хүрд юм уу, Нарны бурхны долоон моринд хөлөглөн тэнгэрээр зорчдог тэрэгний хүрд дугуй гэсэн утгатайгаас гадна Вишнү тэнгэрийн тэмдэг юм. Мөн газар хэмжих нэгжийг заадаг (Beer, 1999: 160) байна. Үүнээс эргэлдэж буй хүрд нь төр болоод шашны эрхийг төлөөлдөг ажээ.

Эрдэмтэд Чакравартин хааны тухай үзлийг нийтийн тооллын өмнөх тавдугаар зуунаас өмнө үүссэн гэж үздэг. Учир нь “Упанишид”, “Арташастра”, “Махабхарата” зэрэг алдартай зохиолуудад энэ үзэл тусгалаа олсон байдаг. Тийм ч учраас Буддаг төрөхөд тохиосон ер бусын явдлууд болон түүний бие дээрх тэмдгүүдийг зөнч Ашита тайлж хэлэхдээ “Бүгдийг эрхшээх хаан (чакравартин), эсвэл төгс гэгээрсэн Будда болно” гэдэг. Чакравартин хаан мэндлэх нь итгэл үнэмшил, ёс суртахуун, үнэнч зан, даруу байдал, эрдэм мэдлэг, татгалзал түдгэлзэл, цэцэн ухаан гэсэн долоон зүйл дэвжихийг дохио болж, долоон эрдэнэ зэрэг тодордог. Эдгээрээс хүрд, чандмань хоёр түүний төр болон шашны эрх сүрийг, морь, заан хоёр хязгааргүй хүч, хурдыг, хатан, түшмэл, жанжин гурав хайр, ухаан, эрх гурвыг тус тус бэлгэддэг.

Чакравартин хааны долоон эрдэнийг монгол хэлнээ “Хан төрийн долоон эрдэнэ” (Нямбуу 1990: 52; 1993: 7), (Шагдаржав ба Лувсандорж 2000: 60), (Самданмөнх ба Цэдэндамба, 2004: 19), “хаан төрийн долоон эрдэнэ” (Урангуа, 2011: 48-49; Монголчууд, 2016: 10) гэж хоёр янзаар нэрлэж, утга бэлгэдлийг нь Х.Нямбуугийн “Өвөөгийн өгүүлсэн түүх” (1990) номоос эшлэн авцгаажээ.

“Хан” гэдэг үгийн утгыг “Монгол хэлний их тайлбар толь”-д “1. Аймгийг ахалсан хүнд олгодог цол, 2. [хуучирсан] Овог аймгийн тэргүүн, ахлагч, эртний монголын эцгийн эрхт ёсны үеийн зайран бөө, түүний цол” гэж, “хаан” гэх үгийг “Үе улиран залгамжилж улс, аймгийн эрхийг ганцаараа эзэгнэгч” гэж тус тайлбарлажээ. Чакравартин нь “бүгдийн эзэн, хаан” учир “хан” бус “хаан төрийн долоон эрдэнэ” гэдэг нь зөв ажээ. Ингээд Монголд дэлгэрсэн хаан төрийн долоон эрдэнийн тайлбар магтаал (Нямбуу, 1990: 7-9)-ыг “Төвөд дүрс, бэлгэдлийн нэвтэрхий толь” (Beer, 1999: 162-163)-д буй төвөд тайлбартай харьцуулж үзье.

Хүрд эрдэнэ (Англи. The Precious Wheel; Самгарди. chakraratna; Төвөд. ‘khor lo rin po che)

Монгол: *Хүрд эрдэнэ гэгч нь алтан эрдэнээр өөрөө бүтсэн, ариун номын эгшигийг дуурьсган эргэдэг хорол болно. Энэ нь төр улс, айл гэр, хүн ард нь номын гэрлээр гийгүүлэгдэн юунд ч дийлдэшгүй бат байхыг бэлгэджээ. Ийм тэмдгийн дүрс нь монгол гэрийн хорол тооно болно.*

Төвөд: *Мянган хигээст хүрд нь хаан төрийн хамгийн чухаг эрдэнэ юм. Машид гэрэлт энэ алтан хүрдний хигээснүүд нь Буддын шашны сургаал номлолын дэлгэрэл хийгээд Буддын олон дүрийг бэлгэддэг. Хүрд эрдэнийг ихэвчлэн найман хигээстэй дүрсэлдэг нь найман гишүүнт хутагт мөрийг төлөөлнө. Асар том хүрд эрдэнэ наран мэт гэрэлтдэг.*

Чандмань эрдэнэ (Англи. The Precious Jewel; Самгарди. maniratna; Төвөд. nor bu rin po che)

Монгол: *Чандмань эрдэнэ гэдэг нь гадаад их далайгаас залж авчирсан, гайхамшигт ид шидтэй, хүн бүгдийн хүслийг хангадаг норов эрдэнийг хэлнэ. Тиймээс энэ эрдэнэ гурав буюу таван дүрсээс бүтдэг. Гурван зууван дугуйг нь чандмань гэдэг, тавыг нь зэндмэнэ, норов гэдэг. Гурван дүрс нь бие, хэл, сэтгэл гурвын хүслийг хангах, таван дүрс нь тэгш таван хүсэл буюу таван мэдрэхүйн баясгалан (харах, амтлах, үнэрлэх, сонсох, хүртэхийн цэнгэл)-г хангана гэсэн утгатай болно. Энэ учраас чандмань тамга, зэндмэнэ эрдэнэ зэрэг үг нь монгол хэлнээ ихэд хүндтэй ховор нандин эрдэнийг төлөөлсөн утгатай болжээ.*

Төвөд: *Хүслийг хангагч чандмань эрдэнэ харанхуйг гийгүүлэх, халууныг сэрүүцүүлэх, хүйтнийг бүлээцүүлэх, хур буулгах, үер ус хийгээд аадрын аюулыг зайлуулах, шаналал зовлонг үлдэх, гэрлийнх хүрээнд орсон бүхний элдэв өвчнийг анагаах зэрэг ид шидтэй. Чандмань эрдэнэ нь өө сэвгүй, найман бүрдэлтэй, нар мэт сацарсан, оюу номин мэт бөгөөд ихэвчлэн морин эрдэнийн эмээл дээр юм уу, түшмэл эрдэнийн баруун гарт буйгаар дүрслэгддэг.*

Хатан эрдэнэ (Англи. The Precious Queen; Самгарди. raniratna; Төвөд. btsun mo rin po che)

Монгол: Хүний ёсонд эмэгтэй хүн, эхнэр, эх хүн нь хүн төрөлхтний нэгэн бат түшиг, тулгуур хань нь байдаг тул төр улс, айл гэрт үзэсгэлэн төгс, ухаан бүрдсэн, эрдэм гүйцсэн, журамтай бүсгүй нэн чухал гэдэг. Иймээс үйлийн муу гэмийг тэвчсэн, үргэлжид амгалангаар цэнгүүлэгч, үнэн ариун хатныг хан (хаан Д.Н) төрийн долоон эрдэнийн нэгэн болгожээ

Төвөд: Хамгийн үзэсгэлэнт бүсгүй бол хатан эрдэнэ юм. Бие нь гаврын үнэрт, амьсгаа нь үдшээр цэцэглэгч бадмын анхилантай ажээ. Тэнгэрлэг бүсгүйн гучин хоёр шинжийг агуулж төрнө. Үүнд, сүмбэн хуруу, цэх нуруу, гэрэлт нүд, тугалынх мэт сормуус, өтгөн буржгар хөмсөг, час улаан уруул, зөөлөн нарийн хэл, үзэсгэлэнт хар үс тэргүүтэн орно. Мөн хатуу, бумбагар хөх, зөөлөн, сэргэр хөхний товч, бадмын хэлбэрт хүйсийн нүх, нууцын орон нь гаднаасаа хуягт мэлхийн нуруу мэт төвгөр байх ажээ. Арван зургаан настай онгон охин мэт сэргэлэн цовоо, дур булаамын дээр хатагтайн найман төгөлдөр чанарыг эзэмшиж, эр нөхөртөө үнэнч, хар хорын сэтгэлгүй, олон хөвгүүн төрүүлнэ. Эр нөхрийнхөө эзэнт улсын сайн сайхны төлөө санаа тавьж, хүчин зүтгэхийн зэрэгцээ төрөлхийн цэцэн ухаантай, үргэлж нөхрийнхөө талд зогсоно. Хэзээд үнэнийг өгүүлэгч, дэмий сул үггүй, гял цалд үл автагч, хөнгөн, хуумгай бодолгүй, эр нөхрөө дээдлэн хүндэлж, бурхны номыг даган баясагч байх ажээ.

Түшмэл эрдэнэ (Англи. The Precious Minister; Самгарди. parinayakarātna; Төвөд. blon po rin po che)

Монгол: Хамаг олон амьтныг эрхшээсэн хатуу цаазаар бусдыг үл айлгагч хатгалдахын сэтгэлээр хэрэг бүгдийг хазгай буруу шийтгэхийг огоот тэвчсэн ханилсан нөхөдтэйгөө үргэлжид зөвшигч хаа явавч олон бүгдээр хүндлэх харилтгүй зоригт түшмэл эрдэнэ нь хан (хаан Д.Н) төрийн долоон эрдэнийн нэгэн аж.

Төвөд: Түшмэл эрдэнэ нь мянганы цаадхыг харж чадах билгийн мэлмий, хурц ухаантай, тэсвэр тэвчээртэй, бусдыг сонсохдоо гаргууд, хааны эрхэм зөвлөгч юм. Гол ажил нь бурхны сургаал номлолыг түгээн дэлгэрүүлж, бүхий л амьд амьтныг хайрлан хамгаалах ажээ. Үүний зэрэгцээ хааны санг барьж баяжуулна. Иймд түшмэл эрдэнийг сан баригч гэх нь ч бий. Хаан эзнийхээ бодлогыг бүрэн ойлгож, төр, шашин, нийгэм гээд бүхий л салбарт нэвтэрхий байх ажээ. Түшмэл эрдэнэ баруун гартаа голдуу үнэт эрдэнэсийн хайрцаг юм уу, зэндмэнэ эрдэнэ барьсан байдаг.

Заан эрдэнэ (Англи. The Precious Elephant; Самгарди. hastiratna; Төвөд. glang po rin po che)

Монгол: Цаст уулын өнгө лүгээ тэмцэлдсэн
Цагаан өнгө нь гялалзаж тодорсон
Цаана наанаас харшлагчийг буцаах
Цааш эргэж бусдыг хорлохгүй
Цаг мөчийн дотор замбативийг эргэн ирэх
Цанган өлсөхийн зүдрэл бүхнийг тэвчсэн
Цогцолсон олон эрдэнийн ачаатай
Цаглашгүй эрдэм төгс заан эрдэнэ нэг эрдэнэ.

Төвөд: *Хаан төрийн заан эрдэнэ нь мянган зааны хүчтэй, уул шиг том биетэй, цас шиг цагаан биетэй, бүх эр зааныг тэргүүлэн захирдаг. Духнаас нь ялгарах анхилуун үнэрт бусад заан өөрийн эрхгүй татагддаг байна. Долоон хуруут дөрвөн хөл, хошуу, хүчирхэг хоёр соёотой. Хошуу, сүүл, хуухнаг нь газарт шүргэнэ. Буддагийн гучин хоёр лагшингийн гол шинжсийн нэгд “бэлгэ эрхтэн нь зааных мэт нугаларсан” гэж байдаг. Заан эрдэнийг зургаан соёотойгоор дүрсэлсэн байх нь бий.*

Тулалдаанд орохдоо эцэж цуцашигүй, аймшиггүй зоригтой, хүний хорвоог өдөрт гурвантаа тойрч чадна. Энхийн цагт цэцэн мэргэн, цог жавхлантай, алхаа гишгээ нь аядуу зөөлөн, галбир төрх сүрлэг үзэсгэлэнтэй. Хаан эзэндээ дуулгавартай захирагддаг, зөн совингоороо хүсэл зоригийг нь мэдэж дагадаг байна. Алтан хүзүүвчтэй, нарийхан хилэн жолоотой. Нуруун дээр нь ихэвчлэн хүрд эрдэнэ юм уу, өглөгийн завьяа тавьсан буйгаар дүрсэлдэг.

Морин эрдэнэ (Англи. The Precious Horse; Самгарди. ashvaratna; Төвөд. rta mchog rin po che)

Монгол: *Тэгш сайхан гоолиг өндөр биетэй
Тэнхэл чадал, өнгө бялд төгссөн
Тэрэгнээс зөөлөн үлэмж аятай явдлаар
Тэмүүлж татаж алхлан жороолсоор
Тэр гэхийн завсар ертөнц бүгдийг эргэх
Тэнгэр хүн бүгдийг сэтгэлд зохистой
Тэнцэшигүй эрдэм төгс морин эрдэнэ.*

Төвөд: *Хаан төрийн морин эрдэнэ нь гучин хоёр шинжтэй, эцэж цуцашигүй салхи мэт, хүний хорвоог нэгэн өдөрт гурав тойрох чадалтай ажээ. Бие нь хун мэт цагаан, бурхны алтан тоногтой дүрслэгдэхийн зэрэгцээ зарим уламжлалд тогосны хүзүү мэт хар хөх, дөрвөн тивийг эгиний дотор туулах чадвартай ч гэдэг. Арван мянган ширхэгт зөөлөн дэлтэй, сүүлт одных мэт намирсан урт сүүлтэй, галбир төрх төгс төгөлдөр ажнай. Хаан эзний ая тавд таацсан хөнгөн, намуун явалтай, эцэж цуцашигүй хөлийнх нь туурай халтиршигүй энэ морин эрдэнэ ихэвчлэн чандмань эрдэнийг эмээл дээрээ тээж явдаг.*

Жанжин эрдэнэ (The Precious General; Самгарди. senapatiratna; Төвөд. dmag dpon rin po che)

Монгол: *Бадмаараг эрдэнийн зүйл бүрийн өртөгтэй
Барагдашигүй эрдэнийн санг барьсан
Баясгалангаар амьтан бүгдийг тэтгэсэн
Баялаг өргөн, дорви чимээ бүрдсэн
Баширлаж ихэс олныг хуурахгүй
Бардагнаж доод олныг дарлахгүй
Баатархаж олон бүгдийг сүрдүүлэхгүй
Балгад мэт орон гэрийг эзлэгч
Бахдам чадал төгс жанжин эрдэнэ.*

Төвөд: *Жанжин эрдэнэ сураар холбож үдэж хийсэн, эртний дайчны хуяг, дуулга асааж, бамбайгаа зүүн гартаа, илдийнхээ үзүүрийг дээш харуулан баруун гартаа тус тус барьсан байдаг нь уулгалан довтолох дайн хийгээд угтан хамгаалах тулалдаанд үргэлж бэлэн буйг бэлгэднэ. Эзэмшсэн ур чадвар, тулалдааны урлагийн жсаран дөрвөн ов мэх нь түүнийг ямар ч тулаанд ялагдашгүй болгожээ. Хаан эзнийхээ хүсэл зоригийг мэдэн дагаж, зарлиг тушаалыг хэлбэрэлтгүй биелүүлнэ. Шударга ёс, үнэний төлөө тэмцэж, муу муухайг арилгахын зэрэгцээ бусдад хор нөлөө үзүүлэхийг ихэд цээрлэнэ. Бурхны сургаал номлол түгэн дэлгэрч, энх тайван, нигүүлсэнгүйн ёсон тогтохын цагт жанжин эрдэнэ хуяг дуулгаа тайлж “өрхийн тэргүүн эрдэнэ” болох ажээ.*

Дээрх хоёр хувилбараас үзэхэд хаан төрийн долоон эрдэнийн монгол тайлбар, магтаал нь төвөд буюу үндсэн эхийн гол утга санааг агуулсан, хураангуй хэлбэртэй байна. Мөн бэлгэдлийг бус утгыг нь илүүтэй хадгалсан шинжтэй ажээ. Хаан төрийн долоон эрдэнээс хүрд эрдэнийн дүрсийг Богд хааны дээлийн гадуур өмсөх алтан хорготой морин хүрмийн урд хэсэгт хадаж өгсөн байдаг нь эртний Энэтхэгийн Махасамади хаантай адил олноо өргөгдсөн хаан гэдгийг нь тодотгожээ. Мөн түүний төрийн тамгадын бариулыг чандмань эрдэнийн дүрстэй урласан байдаг.

О.Батсайхан *“Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын хаанд өргөмжлөхдөө Энэтхэг, Төвөдийн ёсоор хаан эрдэнийн долоон зүйлийг буй болгохыг эрмэлзсэн боловч яг тусгаар тогтнолоо тунхаглан зарласан 12 дугаар сарын 29-ны өдөр болоход уг эрдэнийн долоон зүйлсийн зарим нь бэлэн болоогүй байжээ гэж үзэж болохоор байна”* (2014: 182) гээд хүрд эрдэнийг хувцсанд нь, чандмань эрдэнийг хааны тамганд, хатан эрдэнийг Дондогдулам, заан эрдэнийг тоглоомон заан болон Оросоос заан худалдан авч бодитоор бүтээхийг эрмэлзсэн гэж үзсэн бол 2016 онд өмнө оноож өгсөн эрдэнэс дээрээ нэмэн түшмэл эрдэнийг Б.Ширнэндамдин, морин эрдэнийг сэтэртэй морь, жанжин эрдэнийг манлай баатар Ц.Дамдинсүрэн (Монголчууд, 2016, 104-105) гэж гүйцээж өгчээ. Түүний энэ оноолт өнгөц харахад байж болох мэт ч лавшруулж үзвэл учир дутагдалтай юм. Учир нь Богд зөвхөн заан гэлтгүй ховор амьтад, шувуу, Хималайн баавгай, сармагчин, Энэтхэгийн могой, тоть гээд олон төрлийн амьтад (Оссендовский, 2005, 251)-ын хүрээлэн, бусад ховор сонин зүйлсийн цуглуулгатай байсныг харж болно. Дондогдулам хатны тухайд Богд түүнтэй хаанд өргөмжлөгдөхөөсөө өмнө ханилж, Манжийн хаанд мэдүүлж, Цагаан дара, Эрдэнэ сэцэн ноён хэмээх цол өргөмжлүүлж байсан (Жамсран, 1992: 166)-ыг бодох хэрэгтэй. Баримттай гэж болох хоёр эрдэнийн тухайд ийм үгүйсгэл байж болох бол бусад эрдэнийн тухайд бодитоор бүтээсэн гэх баримт алга.

Ийм яриа гарах үндэс нь Х.Нямбуугийн *“1911 онд Богд гэгээнийг төрийн тэргүүнээр өргөмжлөөд эл долоон эрдэнийг биетээр болгосон байна”* (1990: 7) гэх өгүүлбэр байж болох ч тэрбээр дээрх мэт оноолт хийлгүй, тэдгээрийн тайлбар, магтаалыг хавсаргасан байдаг нь хаан өргөмжлөх их ёслолын үеэр өргөсөн долоон эрдэнийн дүрсийг хэлж байна гэх бидний саналыг бататгаж байгаа юм.

Хаан төрийн долоон эрдэнэ бол Хүннү гүрний үеэс эхтэй монгол төрийн есөн их бэлгийн уламжлалыг халж монгол төрийн бэлгэдэлд орж ирсэн Энэтхэг, Төвөдийн шашин, төрийн бэлгэ тэмдэг юм. Үүнийг Ж.Цэвээний 1912 оны нэгдүгээр сарын 22-ны өдөр В.Л.Котвичид бичсэн захидлаас харж болно. Тэрбээр “Одоо бүхий л цааснууд “Олноо өргөгдсөний тэргүүн он”... тэдэн сарын тэдний өдөр гэж бичиж байна. Энэ бол Энэтхэгийн Махасамади хаан, Наран гэрэлт хэмээх нь мөн л Энэтхэгийн домогт гардаг хааны нэр юм. Нэгэн зүйл миний гайхлыг төрүүлэв, юу вэ хэмээвээс Чингисийн үеийн уламжлал алга байсан явдал” (Ширэндэв, 1972: 136) гэж онцлон тэмдэглэжээ.

Тусгаар тогтнолоо сэргээж, “Монгол Улсын эртний их Чингис хааны үрийн үр, Түшээт ханы хөвгүүдээс дараалан шинж тэмдэг тодорхойгоор хувилж гурван цагийг илэрхийгээр заасаар өчнөөн зуун жилд олноо өргөгдсөн шашныг мандуулах, амьтныг жаргуулагч аврал итгэл хамгийг айлдагч оройн чандмань эрдэнэ арга билгийг хосолж таалан зохиосон Очирдара гэтэлгэгч Богд гэгээнтнээ Монгол Улсын шашин төрийг хослон баригч наран гэрэлт түмэн наст Богд хаанд өргөмжлөн” залсан тэр үед эртний Энэтхэг, Төвөдийн уламжлал бүхий, олноо өргөгдсөн, шашин төрийг хослон баригч хааны бэлгэ тэмдэг хаан төрийн долоон эрдэнийг бүтээж өргөсөн нь бас ч гайхан эргэлзэх аргагүй, зүй ёсны хэрэг байжээ.

Дүгнэлт

Богд хаант Монгол Улсын төрийн бэлгэдлийг хуульд тусгагдсан байдлаар нь албан ёсны болон албан бус гэж хоёр ангилж болно. Албан ёсны бэлгэдэлд “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-т хуульчилж өгсөн төрийн сүлд, төрийн далбаа, төрийн тамга гэсэн гурван бэлгэ тэмдэг орж буй бол албан бус бэлгэдэлд хэдий хуульчлан батлаагүй ч хэрэглэж байсан төрийн дуулал, хаан төрийн долоон эрдэнэ зэрэг бэлгэ тэмдэг орно.

Монгол Улсын албан бус, төрийн дуулал “Зуун лангийн жороо луус” дууны тухайд Богд гэгээнийг тодруулан өргөмжилсөн үйл явдлаас эхлэн түүнийг хаан сэнтийд залсныг өгүүлж, олон түмэн шавь, ноёд сайдууд хүрээлэн мандал өргөж, амь насаа даатгаж, хүслээ ханган хүндлэн биширч буйг илэрхийлж эцэст нь дайсан хортон дарагдаж даяараа жаргах ерөөлөөр өндөрлөжээ. Монгол Улсын Засгийн газраас тусгайлан захиалж гадаадын мэргэжлийн хөгжмийн зохиолчоор аяыг нь зохируулсан энэ дуу монгол төрийн дууллын үүсгэлийг тавьсан нь гарцаагүй юм.

Хаан төрийн долоон эрдэнийн тухайд эртний Энэтхэгээс үүсгэлтэй энэхүү бэлгэ тэмдгээр Богд хааныг Хүрдэн орчуулагч хааны адилаар олноо өргөгдсөн, наран гэрэлт түмэн наст, шашин төрийг хослогч баригч хаан болохыг харуулжээ.

Ном зүй

Архив

Үндэсний Төв Архив, ф. А3, д. 1, х. н. 2

Ном

Монгол хэлээр

Батсайхан, О. (2014). *Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба*. (Гурав дахь хэвлэл).

Улаанбаатар: Соёмбо Принтинг.

Болдбаатар, Ж. (2003). *Түүх зулсан он жилүүдийн ойллого (II)*. Улаанбаатар: Монгол.

Жамсран, Л. (1992). *Монголчуудын сэргэн мандалтын эхэн*. Улаанбаатар: Соёмбо.

Жамсранжав, Г. (1969). *Анхны алхам* (Хориод оны үеийн утга зохиолын тойм). Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Нямбуу, Х. (1979). *Монголын бэлгэдэл*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Нямбуу, Х. (1990). *Өвөөгийн өгүүлсэн түүх*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Нямбуу, Х. (1993). *Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын төрийн ёс, ёслол*. Улаанбаатар: Шувуун саарал.

Самданмөнх, Д ба Цэдэндамба, С. (2004). *Төрийн сүлд ивээ*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Урангуа, Ж. (2011). *Монгол төрийн соёрхол*. Улаанбаатар: Мөнхийн Үсэг.

Хорлоо, П. (1981). *Монгол ардын дууны яруу найраг*. Шинжлэх Ухааны Академийн Хэвлэл.

Хүрэлбаатар, Л ба Жамсранжав, Г. (2010). *Монголын найман богд*. Улаанбаатар: Бит Пресс.

Цэдэв, Д. (2005). *Шүлэг аялгууны шүтэлцээ*. Улаанбаатар: Интер Пресс.

Шагдаржав, Г ба Лувсандорж, Г. (2000). *Монгол Улсын Төрийн ордон* (Нэгдүгээр боть). Улаанбаатар: Адмон.

Ширэндэв, Б. (1972). *В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг*. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн Хэвлэл.

Гадаад хэлээр

Beer, Robert. (1999). *The Encyclopedia of Tibetan Symbols and Motifs*. Boston: Shambhala Publications, Inc.

Владимирцов, Борис Яковлевич. (1970). *Образцы монгольской народной словесности*. Ленинград: Институт живых восточных языков имени А.С. Енукидзе.

Оссендовский, Антоний Фердинанд. (2005). *Люди, боги, звери*. Москва: Яуза, ЭКСМО.

Эмхэтгэл

Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг. (2018). Улаанбаатар: Соёмбо Принтинг.

Монголчууд: 1911-1924 онд (Тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан нь), (Гурав дахь хэвлэл). (2016). Улаанбаатар: Монсудар.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

Дулам, С. (2010). Богд Жибзундамба хутагтын тухай дуунуудын үгийн харьцуулал. *Lamas Journal*, 12 дугаар сар, № 4.

Сонин, сэтгүүл

Дэмбэрэл, Д. (1988). Алдарт дууч, аварга бөх. Соёл, урлаг, № 4, 41.

Норовсамбуу, А. (1999). “Зуун лангийн жороо луус”-ыг хэн зохиогоо юм бол. *Хонгорзул*, № 43-45

Цэнджав, До. (2006). Өөрчлөхөөс аргагүй болоод л зарлигдаж байгаа хэрэг. *Өнөөдрийн Монгол*, хоёрдугаар сарын 16, № 30.

Цахим

Монгол хэлний их тайлбар толь: <https://mongoltoli.mn/dictionary/detail/105314>

Abstract

When the state symbolism of the Bogd Khanate of Mongolia was created, a dual state symbolism was adopted, incorporating both Mongolian state symbolism originating from the era of the Hunnu Empire and state symbolism rooted in ancient India.

The specific features of the state symbolism of the Bogd Khanate consisted of elevating the majesty and authority of the absolutist, theocratic Khan, as represented by each symbol, adopting ancient Indian state and religious symbolism, and reflecting international norms. These features collectively asserted Mongolia's status as an independent sovereign nation.

The state symbols of the Bogd Khanate of Mongolia can be classified into two types by legal status: official and unofficial. The official symbols included the state emblem, the state flag, and the state seal, all enacted in the “Mongolian Legal Rescript Enacted by Decree.” On the other hand, the unofficial symbols

included items like the national anthem and the Seven Imperial Treasures, which were utilized despite not being legally enacted.

This paper examines the tradition and modernization of the unofficial state symbolism of the Bogd Khanate of Mongolia. In doing so, it compares and analyzes research on the national anthem and interpretations of the Seven Imperial Treasures to clarify their meanings and symbolism.

Key words: Pacer mule worth a hundred silver coins, national anthem, seven imperial treasures



Зураг 1. Богд хаант Монгол Улсын төрийн долоон эрдэнэ (Батсайхан, 2014: 220)